



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/316

Чингис хот

Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн
ангийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6, 22.8, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 Засгийн газрын 2020 оны 347 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”, Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн ангийн дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах орон нутгийн алба, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулсугай.

2. Аймгийн гамшгаас хамгаалах орон нутгийн албадын жагсаалтыг нэгдүгээр, гамшгаас хамгаалах тусгай зориулалтын мэргэжлийн анги байгуулах алба, хуулийн этгээдийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангиудыг 2020 оны 11 дугаар сарын 13-ны дотор шинэчлэн байгуулж, тэдгээрийн сургалт, бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, үйл ажиллагааг нь зохицуулахыг бүх алба, сумдын Засаг дарга, албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлагаар ханган ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д, Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/353 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010947

Аймгийн Засаг даргын 2020 оны
дугаар сарын 13 өдрийн 1516
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

№	Гамшгаас хамгаалах орон тооны бус албадын нэр	Байгууллагын нэр
1	Эрүүл мэндийн алба	Эрүүл мэндийн газар
2	Хүнс хөдөө аж ахуйн алба	Хүнс хөдөө аж ахуйн газар
3	Түлш эрчим хүчний алба	Цахилгаан түгээх сүлжээ салбар
4	Хэв журам сахиулах алба	Цагдаагийн газар
5	Сурталчилгааны алба	АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
6	Мэдээлэл харилцаа холбооны алба	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК
7	Зам тээврийн алба	Авто тээврийн үндэсний төвийн Хэнтий аймаг дахь салбар
8	Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх алба	Ус, цаг уур, орчны шинжилгээний алба
9	Барилга хот байгуулалтын алба	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
10	Мэргэжлийн хяналтын алба	Мэргэжлийн хяналтын газар
11	Хүн ам, нийгмийн хамгааллын алба	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
12	Мал эмнэлэгийн алба	Мал эмнэлгийн газар

№	Мэргэжлийн ангийн нэр	Мэргэжлийн ангийн ангилал	Алба, хуулийн этгээдийн нэр
1	2	3	4
1	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэргэжлийн анги	Яаралтай тусламжийн бүлэг	Эрүүл мэндийн газар
		Хээрийн эмнэлэг	
		Цус сэлбэх хөдөлгөөнт бүлэг	
		Эм эмнэлгийн хэрэгслээр хангах бүлэг	
		Зоонозын өвчинтэй гэмцэх бүлэг	
		Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлэг	
2	Нийгмийн хамгааллын мэргэжлийн анги	Хүүхэд хамгаалал, боловсролын бүлэг	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
		Өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах бүлэг	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
3	Хүмүүнлэгийн тусламжийн мэргэжлийн анги	Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бүлэг	Онцгой байдлын газар
		Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн бүлэг	
4	Хэв журам сахиулах ажиллагааны мэргэжлийн анги	Хэв журам сахиулах бүлэг	Цагдаагийн газар
		Тусгай бүлэг	
5	Санхүү нөөц хангалтын мэргэжлийн анги	Санхүү нөөцийн бүлэг	АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс
		Хүнсний хангалтын бүлэг	АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
		Орон байр хувцас хангалтын бүлэг нийг	АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс
		Тээврийн бүлэг	Авто тээврийн үндэсний төвийн Хэнтий аймаг дахь салбар
		Шатахуун хийн түлш, хангалтын бүлэг	АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
6	Нүүлгэн шилжүүлэлт, түр байр хариуцсан мэргэжлийн анги	Нүүлгэн шилжүүлэлт, түр байрны бүлэг	Авто тээврийн үндэсний төвийн Хэнтий аймаг дахь салбар
7	Хоргодох байр хариуцсан мэргэжлийн анги	Хоргодох байрны бүлэг	АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс
8	Хүнс хөдөө аж ахуйн мэргэжлийн анги	Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн бүлэг	Хүнс, хөдөө аж ахуйн газар
		Ургамал, газар тариалан хамгаалах бүлэг	
		Ариутгал халдваргүйжүүлэлтийн бүлэг	
9	Гал түймэр унтраах ажиллагааны мэргэжлийн анги	Гал түймэр унтраах бүлэг	Онцгой байдлын газар

1	2	3	4
10	Усны сан бүхий газар, уст цэг хамгаалах мэргэжлийн анги	Цэвэр, бохир усны засварын бүлэг	Хэнтий ус ОНӨХХК
		Уст цэг хамгаалах бүлэг	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
11	Дулаан хангамжийн мэргэжлийн анги	Дулааны шугам сүлжээний засварын бүлэг	Хэнтий ус ОНӨХХК
12	Цахилгаан хангамжийн мэргэжлийн анги	Цахилгаан, шугам сүлжээний засварын бүлэг	Цахилгаан түгээх сүлжээ салбар
13	Зам, гүүрийн засвар, үйлчилгээний мэргэжлийн анги	Зам, гүүрийн засварын бүлэг	Харгуй ТӨХК
14	Инженер, тэсэлгээний мэргэжлийн анги	Инженер, тэсэлгээний бүлэг	АЗДТГ-ын дэргэдэх Цэргийн штаб
15	Цацраг, химийн хяналт	Цацраг, химийн хяналтын бүлэг	Ус, цаг уур, орчны шинжилгээний алба
16	Харилцаа холбоо, зарлан мэдээллийн мэргэжлийн анги	Харилцаа холбоо, зарлан мэдээллийн бүлэг	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК
17	Мэдээлэл, сурталчилгааны мэргэжлийн анги	Мэдээлэл, сурталчилгааны бүлэг	АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
18	Иргэний бүртгэл мэдээлэл, статистик судалгааны мэргэжлийн анги	Иргэний бүртгэл, мэдээллийн бүлэг	АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс
		Статистик мэдээллийн бүлэг	АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс Статистикийн хэлтэс
19	Төмөр замын засвар, үйлчилгээний мэргэжлийн анги	Төмөр замын засварын бүлэг	Улаанбаатар төмөр замын Бор-Өндөр өртөө
20	Нисэх буудлын аюулгүй байдлын мэргэжлийн анги	Нисэх буудлын аюулгүй байдлын бүлэг	Нисэх онгоцны буудал
21	Хуулийн этгээдийн мэргэжлийн анги	Анхны тусламжийн нэхөрлөл	Байгууллага аж ахуйн нэгж
		Аврах, гал унтраах бүлэг	
		Ухуулга, сурталчилгааны бүлэг	